



# СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№99 /543/

2023.06.17

Цаг үе, үйл явдал

## “ХААНЫ ЭРЭЛД” ОЛОН УЛСЫН СУРГУУЛЬ НЭЭЛТЭЭ ХИЙЖ БАЙНА



Монгол Улсын Зэвсэгт хүчин, Америкийн Нэгдсэн Улсын Номхон далай дахь Хуурай замын командлал хамтран жил бүр зохион байгуулдаг “Хааны эрэлд-2023” энхийг дэмжих ажиллагааны олон улсын сургууль Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвд яг одоо болж байна.

Энэ жилийн сургуульд дэлхийн 25 орны 1100 гаруй цэргийн алба хаагч оролцож байна. Оролцогч орнууд уг олон улсын сургуулиар команд штабын сургууль, салаадын хэргийн

сургууль, чадавхыг нэмэгдүүлэх сургалтад тус тус хамрагдана. Энэхүү сургуульд Бүгд Найрамдах Лаос Ард Улсын цэргийн алба хаагчид анх удаагаа оролцож байгаа юм.

Энэхүү олон улсын сургуулийн нээлтийн ёслолын ажиллагаанд Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд, дэслэгч генерал Г.Сайханбаяр, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн

бичгийн дарга Ж.Энхбаяр, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх, бэлтгэл дэслэгч генерал Ц.Тогоо, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга бригадын генерал С.Ганбямба, БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Д.Ганхуяг, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр гадаад улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдууд, батлан хамгаалахын атташе нар, Номхон далай дахь АНУ-ын Хуурай замын цэргийн командлагчийн орлогч хошууч генерал Крис Смит болон сургуульд оролцогч зарим улсын хүндэт зочид, цэргийн төлөөлөгч нар оролцож байгаа юм.

Энэ жилийн сургуулийн удирдагчаар Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн дарга, хурандаа Б.Мөнх-Ирээдүй, сургуулийн штабын даргаар Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвийн Энхийг дэмжих ажиллагааны Сургалтын төвийн дарга, дэд хурандаа Н.Гантулга нар ажиллаж байна.

Энэхийг “Хааны эрэлд” энхийг дэмжих ажиллагааны сургуулийг зохион байгуулж эхэлсний 20 жил, мөн Монгол Улсын Зэвсэгт хүчин энхийг дэмжих ажиллагаанд цэргийн баг илгээж Ирак болон Афганистаны дайны дараах сэргээн босголт, аюулгүй байдлын төлөө хувь нэмрээ оруулсны 20 жилийн ой давхцаж байгаагаараа онцлогтой.

Энэхүү олон улсын сургууль нь анх 2003 онд хоёр талын хамтарсан энхийг дэмжих ажиллагааны сургуулийн хэлбэрээр эхэлж байсан бол 2006 оноос “Даян дэлхийн энхийн ажиллагааны санаачилга” хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр олон улсын энхийг дэмжих ажиллагааны сургууль болж өргөжин өдгөө Ази-Номхон далайн бүс нутагт энхийг дэмжих ажиллагааны чиглэлээр зохиогдож буй томоохон сургууль болоод байна.

Энхийг эрхэмлэсэн манай улсын гадаад бодлогод “Хааны эрэлд” олон улсын сургууль нь томоохон байр суурийг эзэлж, эвийн хүч, найрсаг харилцаа, дипломат аргаар энх тайвныг сахин хамгаалах дуу хоолойгоо даян дэлхийд түгээхийн зэрэгцээ Монгол Улсын Зэвсэгт хүчний сургалт бэлтгэл, үүрэг гүйцэтгэх чадавхыг дээшлүүлэх, манай улсын цэргийн алба хаагчдын төдийгүй дэлхийн олон орны энхийг сахиулагчдын мэдлэг, ур чадвар, дадлага, туршлагыг нэмэгдүүлэхэд өндөр ач холбогдолтой юм.



## АХЛАХ БАЙЛДАГЧ Б.БАТТУШИГ ЦЭРГИЙН АЛБАНААС ИХ СУРГУУЛИА АМЖИЛТТАЙ ДҮҮРГЭЛЭЭ



Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагч, ахлах байлдагч Б.Баттушиг өнөөдөр ШУТИС-ийн төгсөгчдийн баярт чөлөөгөөр оролцож, мэргэжлийнхээ дипломыг гардан авлаа.

Тэрээр ШУТИС-ийн Эрчим хүчний сургуулийг “Сэргээгдэх эрчим хүчний инженер” мэргэжлээр дүүргэсэн бөгөөд цэргийн алба хааж буй хугацаандаа цахимаар суралцаж, дипломын

ажлаа амжилттай хамгаалсан хоёрдох тохиолдол боллоо.

Ташрамд дуулгахад өнгөрсөн 1 дүгээр сард мөн тус ангийн хугацаат цэргийн алба хаагч, байлдагч А.Амар цэргийн алба хаах хугацаандаа цахимаар суралцаж ШУТИС-ийн Эрчим хүчний сургуулийг “Цахилгаан хангамж” мэргэжлээр дүүргэж байсан юм.



Ийнхүү Зэвсэгт хүчинд хугацаат цэргийн алба хаангаа их, дээд сургуульд цахимаар суралцаж, дипломын ажлаа хамгаалах, гадаадын их сургуулийн тэтгэлэгт өрсөлдөх, элсэлтийн болон төрийн албаны шалгалтад бэлтгэх зэрэг олон боломж байдгийг ахлах байлдагч Б.Баттушиг, байлдагч А.Амар нар өөрсдийн биеэр батлан харууллаа.

### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 23	🌧️ 7


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 34	🌧️ 24

### ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,430	3,438
EUR 🇪🇺	3,740	3,780
CNY 🇨🇳	484	488
RUB 🇷🇺	40.60	41
JPY 🇯🇵	24.55	24.90
KRW 🇰🇷	2.65	2.68

### ЗУРХАЙ



**ЗУНЫ ДУНД ШАР МОРЬ САР НАЙМАН ЦАГААН МЭНГЭТЭЙ ШАР БИЧ ӨДӨР**

Үс засуулбал:

Нас ахар болно

Наран ургах, шингэх:

04.53-20.54

Барилдлага:

Рашаан

Шүтэн барилдлага:

Хүрэлцэхүй

Тухайн өдөр нохой, хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Эл өдөр насны хүч дэлгэрнэ. Эм найруулах, угаал үйлдэх, бэр авах, насны авшиг, насны бүтээл хийх зан үйл хийгээд төрөл садан бололцох, худалдаа наймааны үйлнээ сайн болой, хараал дарах, гал мандал хий зэрэгт сайн. Баруун нүд татвал эд олох, баруун чих хангинавал аймшиг болох, зүүн чих жингэнэвэл жуулчин ирэх, хэрээ дуугарвал зочин ирэх, тагнай загатанал амгалан болох, бие татвал эцэг эх цочих, хөл татвал тэмцэл болно.

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 690,595,086

Эдгэрсэн

Нийт: 663,052,141

Нас барсан

Нийт: 6,892,661

Цахим шууданд

СЭТГЭЛ ЗҮЙН ОНОШИЛГОО, СУРГАЛТААР ...



Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагчид, офицер, ахлагч нарт Монгол Улсын Их Сургуулийн Сэтгэл зүйн ангийн багш нар болон оюутнууд Сэтгэл зүйн оношилгоо хийж, сургалт зохион байгуулав. Энэ үеэр "Сэтгэл зүйн эрүүл мэнд", "Зөөлөн ур чадвар", "Хосын харилцаа буюу гэр бүл төлөвлөлт" зэрэг сургалт орж мөн "Стресс", "Түгшүүр", "Аз жаргалын түвшин", "Сэтгэл хөдлөлийн чадвар буюу EQ", "Сэтгэл зүйн сайн сайхан байдал" зэрэгт оношилгоо хийж дүгнэлт гарган ажилласан юм.

ХОЁРДУГААР ЗЭРГИЙН БЭЛТГЭЛ ҮҮРЭГТНҮҮД ЦЭРГИЙН АНХАН ШАТНЫ БЭЛТГЭЛ ОЛГОХ СУРГАЛТАД ХАМРАГДАЖ БАЙНА



Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3.10, 17 дугаар зүйлийн 17.1.6 дахь заалт, Цэргийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6, 33.8 дахь заалт, Батлан хамгаалах сайдын 2018 оны А/313 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2023 оны А/324 дүгээр захирамжийн дагуу Дорнод аймгийн 14 сумын хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтнүүд цэргийн анхан шатны бэлтгэл олгох сургалтад хамрагдаж байна.

Тус сургалт нь 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдрөөс 06 дугаар сарын 22-ныг хүртэл Зүүн бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газар, Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн сургалтын төвийн хээрийн байрлалд зохион байгуулагдаж байна.

Цэргийн анхан шатны бэлтгэл олгох сургалтад хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтнүүд олон, дадлагын хичээлийн мэдлэг олгож байгаа юм.

**ДОРНОД АЙМГИЙН ЦЭРГИЙН ШТАБ**

ЦЭРГИЙН ЧУУЛГЫН ЭРГЭН ТОЙРОНД...



хувьсгалын 102 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 112 жилийн ойн Үндэсний их баяр наадмын нээлт, хаалтын ажиллагааны бэлтгэл ажлыг хангасар байна.

Мөн баяр наадмын нээлт хаалтын үйл ажиллагааны найруулагчийн багт ЦДБЭЧ-ын уран сайхны удирдаач хошууч Л.Баттөр, Үндэсний их баяр наадмын урлаг, соёлын салбар хорооны гишүүнээр ЦДБЭЧ-ын дарга, МУСГЗ хурандаа Г.Золзаяа нар ажиллаж байна. Түүнчлэн чуулгын уран бүтээлчид Төрийн ёслол хүндэтгэлийн арга хэмжээ, Үндэсний их баяр наадмын нээлт, хаалтын ажиллагааны бэлтгэл ажлыг хангахын зэрэгцээ гадаад цэргийн хүндэт зочид төлөөлөгчид, Зэвсэгт хүчний анги байгууллагуудын цэрэг дайчид, ард иргэдэд зориулсан үндэсний урлагийн тоглолтуудыг зохион байгуулсаар байгаа билээ.

ЦДБЭЧ-ын уран өгсөн үүрэг чиглэл, ЦДБЭЧ-ын бүтээлчид Баяр наадмын даргын тушаалын дагуу Тулгар комиссын шийдвэр, БХЯ-ны төрийн 2232, Их Монгол улс Төрийн нарийн бичгийн даргын байгуулагдсаны 817 жил, Ардын

“ЗАМ-2023” ХАМТАРСАН СУРГУУЛИЙН ХҮРЭЭНД ЯПОН УЛСЫН СОЁЛЫН ӨДӨРЛӨГ БОЛЛО



Монгол Улсын Зэвсэгт хүчин, Япон Улсын Өөрийгөө хамгаалах хүчний инженерийн салбарын хамтарсан “Зам-2023” сургуулийн хоёрдугаар шат Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийг түшиглэн амжилттай явагдаж байна.

Сургуулийн үеэр зохион байгуулагддаг уламжлалт нэгэн арга хэмжээ нь хоёр орны “Соёлын өдөрлөг” юм. Энэ удаагийн соёлын арга хэмжээг Япон Улсын сургалтын баг энэ сарын 17-ны өдөр зохион байгууллаа.

Соёлын өдөрлөгөөр Япон Улсын түүх, соёл, уламжлал, үндэсний уран бичиг, үндэсний хөгжөөнт тоглоомоо Монгол Улсын цэргийн алба хаагчдад сурталчлан таниуллаа.

Энэхүү өдөрлөгөөр Япон Улсын цэргийн алба хаагчид “Улаанбаатарын үдэш” дууг Монгол хэл дээр дуулж ая дууны мэндчилгээ дэвшүүлсэн нь Монголын Улсын цэргийн алба хаагчдын талархлыг ихэд хүлээсэн юм.

Ахмад Г.МӨНХБОЛД

Зарлал

**УБХИС-ийн 2023-2024 оны хичээлийн жилийн ЭЛСЭЛТИЙН БҮРТГЭЛ** **эхэллээ.**

**ХӨТӨЛБӨР:** ■ Бакалавр ■ Мэргэжлийн боловсрол

**БҮРТГЭЛ: 06.19-07.06**

Дэлгэрэнгүйг 11 453164, 11 451820 утсаар лавлана уу.

[www.mndu.gov.mn](http://www.mndu.gov.mn)

40 ХУВИЙН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ҮНЭЭР АНГИЛАЛ АХИУЛАХ СУРГАЛТ ЯВУУЛЖ БАЙНА



БХЯ, ЗХЖШ-аас хэрэгжүүлж байгаа нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх ажлын хүрээнд Зэвсэгт хүчний нэгтгэл, анги салбарын офицер, ахлагч, гэрээт болон ХЦАХ-дын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, хувь хүний хөгжил, алба хаагчдын ар гэрийг дэмжих зорилгоор ЗХЖШ-ын даргын тушаалаар Зэвсэгт хүчний 011 дүгээр ангиас жолооны В, С ангилал, бусад ангилал ахиулах сургалтыг 40 хувийн хөнгөлөлттэй үнээр явуулж байна.

Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн Техникийн бага мэргэжилтэн бэлтгэх сургалтын төв энэ удаагийн жолооны сургалтыг Хуурай замын цэргийн командлалын харьяа Зэвсэгт хүчний 336 дугаар ангид 2023 оны 06 дугаар сарын 15-аас 07 дугаар сарын 31-ний өдрүүдэд хөдөлгөөнт бүлгээр явуулж байна.

Энэхүү сургалт нь ЗХЖШ-ын даргын тушаалаар 2022 оны 12, 2023 оны 02, 03, 04, 05 дугаар саруудад явагдсан сургалтын үргэлжлэл бөгөөд одоогоор Зэвсэгт хүчний 400 гаруй алба хаагч, ар гэрийн гишүүдийг хамруулаад байна.

**Ахмад Д.СЭРСЭНДЭМЭД**